



## БАРАА НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Нэг. Ерөнхий зүйл

Нэг талаас "ОД ЭС ЭС" ХХК / цаашид нийлүүлэгч гэх / нөгөө талаас ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ / цаашид захиалагч гэх/ дараах зүйлийг харилцан тохиролцож 2023 оны 06 сарын 01-ний өдрөөс 2023 оны 12 сарын 31-ны өдөр хүртэл харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

### Хоёр. Гэрээний зорилго

Дундговь аймагт үйл ажиллагаа явуулж буй албан байгууллагуудад чанартай эрүүл мэндийн шаардлага хангасан бараа материалаар хангах мөн компанийхаа борлуулалтыг нэмэгдүүлэхэд оршино.

### Гурав. Нийлүүлэгчийн эрх үүрэг

- 3.1 Нийлүүлэгч нь захиалагч талтай сар бүрийн 25-ны дотор тооцоо нийлж байх
- 3.2 Нийлүүлэгч нь чанартай. эрүүл мэндийн шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнээр үйлчлэх үүрэгтэй .
- 3.3 Нийлүүлэгч нь соёлч боловсон хурдан шуурхай үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- 3.4 Нийлүүлэгч нь тендерийн үнийн саналд ирүүлсэн үнээр нийлүүлж. үнийг тогтвортой барих үүрэгтэй.
- 3.5 Захиалсан бараа нь тасарсан нөхцөлд захиалагч талд урьдчилан мэдэгдэж харилцан тохиролцож өөр бараагаар орлуулах зэргээр зохицуулалт хийнэ.
- 3.6 Барааг нийлүүлэгч тал нь тээвэрлэн хүргэж өгнө. Тээвэрлэлтийн явцад гэмтээсэн барааг нийлүүлэгч тал хариуцана.
- 3.7 Нийлүүлэгч нь барааны төлбөр тооцоог гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулахыг захиалагчаас шаардах эрхтэй .

### Дөрөв. Захиалагчийн эрх үүрэг

- 4.1 Захиалагч нь гэрээний дагуу чанарын шаардлага хангасан бараа бүтээгдэхүүнээр хангагдах эрхтэй

4.2 Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг сайтар шалгаж эрүүл ахуйн шаардлага хангасан бүтээгдэхүүн хүлээн авна.

4.3 Бүтээгдэхүүнийг жигнэх жин нь жингийн стандартын шаардлага хангасан байна.

4.4 Захиалагч нь сар бүрийн 25-ны дотор нийлүүлэгч талтай тооцоогоо нийлж байх үүрэгтэй.

4.5 Захиалагч тал гэрээгээ улирлаар дүгнэнэ

4.6 Захиалагч нь сар бүрийн 30-ны дотор ХААН банкны 5466092214 дансанд төлбөрийн тооцоо хийх үүрэгтэй.

4.7 бага үнэтэй бараа материалыг тендерт ирүүлсэн үнийн дүнгийн дагуу худалдан авна.

4.8 Худалдан авсан барааны чанар, тоо хэмжээ, үнэ, бүрэн бүтэн байдлын талаар санал гомдол гарвал зохих шаардлагыг тухай бүрт нь нийлүүлэгчдэд тавьж шийдүүлнэ.

4.9 Захиалагч нь бараа бүтээгдэхүүнийг шалган тоолж авах бөгөөд нийлүүлэгчээс барааны үнэ, тоо ширхэгийг тэмдэглэсэн гарын үсэг бүхий зарлагын падааныг хүлээн авч гарын үсэг зуруулснаар барааг хүлээн авсанд тооцоно.

4.10 Худалдан авсан барааг шалгах явцад гэмтэлтэй болон чанарын шаардлага хангахгүй барааг буцаах эрхтэй.

4.11, Нийлүүлэгч гэрээнд заасан үнийг зөрчвөл захиалагч гэрээг цуцлах эрхтэй.

#### Тав.Бусад зүйл

5.1 Захиалагч нь бараа бүтээгдэхүүн авахад нярав, худалдагч нараас шалтгаалах хүндрэл гарвал нийлүүлэгч талын удирдлагад хандана.

5.2 Гэрээ нь 2 тал гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

5.3 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, сунгах асуудлыг талууд харилцан тохрилцож бичгээр үйлдэнэ.

5.4 Гэрээ зөрчсөн тохиолдолд хамтран зөвшилцөх, хамтын шийдэлд хүрэх замыг сонгон ажиллах ба санал зөрсөн тохиолдолд МУ-ын холбогдох хууль тогтоомжийн дагуу асуудлыг шийдвэрлэнэ.


5.5 Гэрээнд хоёр тал хяналт тавьж ажиллана.

#### НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

Албан тушаал. Менежер

Нэр. Б. Бадамгарав

Утас: 88020677

Гарын үсэг 

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ

Албан тушаал. Нярав

Нэр. Д. Цогтбаяр

Утас: 99906136

Гарын үсэг 